



**ХАН-УУЛ ДҮҮРГИЙН  
ИРГЭНИЙ ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН  
ШҮҮГЧИЙН ЗАХИРАМЖ**

2019 оны 04 сарын 11 өдөр

Дугаар 183/ШШ2019/00865

Улаанбаатар хот

**Хэргийг хялбаршуулсан журмаар  
хянан шийдвэрлэх тухай**

Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч  
Д.Даваасүрэн би,

Нэхэмжлэгч: Сүхбаатар дүүргийн 5 дугаар хороо, Үндсэн хуулийн гудамж,  
Ньюмайд групп ХХК-ийн байранд байрлах, 5039754 регистрийн дугаартай, Лэндмн  
ББСБ ХК-ийн нэхэмжлэлтэй,

Хариуцагч: Хан-Уул дүүргийн 2 дугаар хороо, 107 дугаар байрны 172 тоотод  
оршин суух, 1981 онд төрсөн, 38 настай, ЧР:81061913 регистрийн дугаартай,  
Боржигон овогт Миеэгомбын Цасчихэрт холбогдох

Зээлийн гэрээний үүрэгт 161.700 төгрөг гаргуулах тухай иргэний хэргийг  
хянаад

**ТОДОРХОЙЛОХ нь:**

Нэхэмжлэгч Лэндмн ББСБ ХК-ийн гүйцэтгэх захирал Б.Дэлгэржаргал шүүхэд  
гаргасан нэхэмжлэлийн шаардлагадаа: Лэндмн ББСБ ХК нь М.Цасчихэрийн lendMN  
аппликейшнээр дамжуулан гаргасан хүсэлтийн дагуу 2017 оны 11 дүгээр сарын 06-  
ны өдөр 140000 төгрөгийг 12700 төгрөгийн шимтгэлтэй, 30 хоногийн хугацаатай,  
2017 оны 12 дугаар сарын 06-ны өдөр эргэн төлөх нөхцөлтэй зээлүүлж,  
М.Цасчихэрийн Хаан банкны 5006700023 тоот дансанд шилжүүлсэн. Зээлдэгч  
М.Цасчихэр үндсэн зээлийн дүн болох 140000 төгрөг, шимтгэл 12700 төгрөгийг  
өнөөдрийг хүртэл төлөөгүй байна. Зээлдэгч нь зээлийн гэрээний 4.2.2 дахь заалтыг  
зөрчин, зээлийг хугацаанд нь эргэн төлөх үүргээ биелүүлээгүй тул хариуцагч  
М.Цасчихэрээс үндсэн зээлийн төлбөр 140000 төгрөг, шимтгэл 12700 төгрөг,  
нотариатын үйлчилгээний төлбөр 9000 төгрөг нийт 161700 төгрөгийг гаргуулж өгнө  
үү гэжээ.

Хариуцагч М.Цасчихэр шүүхэд гаргасан тайлбартаа: Лэндмн ББСБ ХК-иас  
нэхэмжилж байгаа 161700 төгрөгийг төлж барагдуулахыг хүлээн зөвшөөрч байна.  
Иймд хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэж өгнө үү гэжээ.

**ҮНДЭСЛЭХ нь:**

Лэндмн ББСБ ХК нь М.Цасчихэрт холбогдуулан зээлийн гэрээний үүрэгт  
161700 төгрөг гаргуулах тухай нэхэмжлэлийн шаардлагыг гаргажээ.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нэхэмжлэгч Лэндмн ББСБ ХК-  
ийн нэхэмжлэлийн шаардлага 161700 төгрөгийг хариуцагч М.Цасчихэр төлөхийг  
хүлээн зөвшөөрч тайлбараа бичгээр ирүүлсэн байна.

Хариуцагчийн зөвшөөрөл нь гуравдагч этгээдийн эрх ашгийг хөндөөгүй, хуульд нийцэж байх тул хариуцагчийн зөвшөөрлийг баталж, хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэх нь зүйтэй гэж үзэв.

Хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэж байгаа тул улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээг тал хувиар бууруулан тогтоож, хуульд заасан журмаар гаргуулахаар шийдвэрлэлээ.

Зохигч давж заалдах, хяналтын журмаар гомдол гаргах, тухайн асуудлаар анхан шатны шүүхэд дахин нэхэмжлэл гаргах эрхгүй болохыг тус тус дурдах нь зүйтэй.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.2, 75 дугаар зүйл, 123 дугаар зүйлийн 123.1 дэх хэсэгт заасныг удирдлага болгон

#### ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Лэндмн ББСБ ХК-ийн нэхэмжлэлтэй М.Цасчихэрт холбогдох зээлийн гэрээний үүрэгт 161700 төгрөг гаргуулах тухай иргэний хэргийн хариуцагч М.Цасчихэр нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрснийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгосугай.

2.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.5, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1-т заасныг баримтлан нэхэмжлэгчээс улсын тэмдэгтийн хураамжид урьдчилан төлсөн 5501 төгрөгний тал хувь болох 2750 төгрөгийг улсын төсвийн дансанд хэвээр үлдээж, улсын төсвийн данснаас 2750 төгрөг, хариуцагч М.Цасчихэрээс 2750 төгрөгийг тус тус гаргуулж, нэхэмжлэгч Лэндмн ББСБ ХК-д олгосугай.

3.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.6 дахь хэсэгт зааснаар энэхүү захирамжийг хариуцагч сайн дураар биелүүлээгүй бол шүүхийн шийдвэрийн нэгэн адил албадан гүйцэтгэхийг мэдэгдсүгэй.

4.Зохигчид давж заалдах, хяналтын журмаар хянан шийдвэрлүүлэхээр гомдол гаргах, тухайн асуудлаар анхан шатны шүүхэд дахин нэхэмжлэл гаргах эрхгүйг дурдсугай.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ



Д.ДАВААСҮРЭН